

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
2017 ОНЫ ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ БОЛОН  
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.01.08

Өмчийн харилцааны талаар

- Орон нутгийн өмчийн харилцаанд мөрдөгдөх “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, “Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”, “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-уудыг шинэчлэн боловсруулж, орон нутгийн өмчит байгууллагуудад хүргүүлэн журмын төсөлд санал авч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан батлуулсан.
- 2017-05-23-нд сумдын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга буюу сумдын Засаг даргын орлогч нарт өмчийн харилцааны шинэчлэн боловсруулсан журмын төслийг танилцуулж, журамд тусгах санал, цаашид анхаарах асуудлын талаар харилцан ярилцаж, заавар зөвлөгөө өгч ажиллаа.
- Мөн аймгийн Засаг даргын 2017 оны А/170 тоот захирамжын дагуу ажлын хэсэг байгуулагдан 05 сарын 22-ноос 06 сарын 15-ны хооронд аймгийн төвийн орон нутгийн өмчит байгууллага болон бүх сумдаар тухайн байгууллаг сумын өмч хамгаалах зөвлөлийн хамт явж Орон нутгийн өмчийн талаар холбогдох бодлого, дүрэм журмыг байгууллагуудад сурталчлах, байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт хадгалалтанд хяналт шалгалт хийж зөвлөгөө өгч ажиллаа.
- 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/364 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө болох байгууллагын гадна инженерийн шугам сүлжээ, суваг, худгийн тооллого хийж, программд оруулах ажлыг гүйцэтгэж ажилласан.
- Орон нутгийн өмчит байгууллагуудын 2016 оны үндсэн хөрөнгийн тайланг орон нутгийн өмчит нийт 144 байгууллагаас хүлээн авч санхүүгийн тайлан баланстай тулгалт хийн нэгтгэлд хамруулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүлээлгэн өгсөн.
- Аймгийн засаг даргын 2017.05.22-ний А/170 захирамж, Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, НББ хөтлөлтийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2017.05.25-29-ний хооронд аймгийн төв болон Сайнцагаан сумын орон нутгийн өмчит байгууллага, 2017.06.05-15-ны хооронд бүх сумдын орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэл ашиглалт, түрээслүүлж буй байдал зэрэгт хяналт тавьж ажиллалаа.
- Өөш, орон нутгийн өмч хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бараа, ажил үйлчилгээ, барилга байгууламжийг хүлээн авах комисст орж орон нутгийн өмчлөлд хүлээн авах, тухайн байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгасан эсэх дээр хяналт тавин ажилласан.
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа ашиглалтгүй болон илүүдэлтэй үндсэн хөрөнгийн тухай асуудлыг байгууллагын ирүүлсэн саналын дагуу хянан судалж, тогтоолын төсөл бэлтгэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар нийт 17 асуудлыг Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж давхардсан тоогтоор хөрөнгө бэлтгэж бүртгэх зөвшөөрөл олгох тухай 4, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай 3, хөрөнгө шилжүүлэх тухай 4, хөрөнгө худалдах зөвшөөрөл олгох тухай 5 нийт 14 тогтоол гаргуулсан. Хөрөнгөтэй холбоотой тогтоол шийдвэрийг холбогдох байгууллага, хүмүүст тухай бүр албан бичгээр мэдэгдэж байна. Мөн хуралдаанд оруулах материал дутуу ирүүлсэн болон бусад шаардлагатай, хугацаатай албан бичигт тухай бүрт хариу өгч ажиллалаа. Аймгийн засаг даргын 2017-09-01-ний өдрийн А/292 тоот захирамжийн дагуу Аймгийн ИТХ, Нийтлэг үйлчилгээ ОНӨҮГазарт хяналт шалгалт хийх ажлын хэсэгт орж ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны талаар

Нэг.Ерөнхий зүйл

**1.1** Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь 2017 оны 01 сарын 05-ны өөр 2,1 тэрбум төгрөгийн **22** бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч буюу Аймгийн Засаг дарга буюу батлуулсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,4 тэрбум төгрөгийн **54** бараа, ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн байна.


Тус 54 худалдан авах ажиллагаанаас Сайнцагаан сумын Засаг даргад аймгийн төвийн хогийн менежментийн 50 сая төгрөгийн төсөв бүхий ажлын эрхийг шилжүүлж гүйцэтгүүлсэн бөгөөд Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг зохион байгуулсан боловч шаарлагад нийцсэн нэг ч тендер ирээгүйн улмаас бүх тендерээс татгалзсан. Захиалагчаас тус ажлын хяналтын төсөв зохиогдохдоо үнийг зах зээлээс хэт өндөр тооцсон буюу төсөв зохиох норм, дурмийн дагуу хийгээгүйн улмаас дахин төсвийг аймгийн ИТХ-аар тодотгон хэлэлцүүлж бодит ажлын төсөвтэй болсон боловч дахин тендерийг зарлахад тус ажлын техникийн нөхцөл ирээгүйн улмаас он дамжин хүлээгдэж байна.

2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 3,359,564,399 төгрөгийн 52 худалдан авалтан авах ажиллагаа зохион байгуулагдаж 3,194,551,221 төгрөгийн гэрээ байгуулагдаж **165,013,178** сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Төлөвлөгөөний биелэлт **98%**-ийн гүйцэтгэлтэй байна.

**Санхүүжилтийн товчоон**





Нийт зохион байгуулсан 52 худалдан авалтаас нээлттэй тендер шалгаруулалтын 11, харьцуулалтын 34, шууд худалдан авах 4 худалдан авалт байна. Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмыг санхүүжилт тус бүрээр харуулбал.



2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрлөөр нь ангилвал ажлын 1,565,738,542 төгрөгийн 14, барааны 1,335,724,728 төгрөгийн 17, 70,000,000 төгрөгийн зөвлөх 1, зөвлөхийн бус 160,383,536 төгрөгийн 2 худалдан авалт тус тус төлөвлөгдсөн байна.



1.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй хийгдсэн 12 худалдан авах ажиллагаа байгаа бөгөөд энэ нь төлөвлөгөө батлагдсанаас хойш байгууллагуудаас хүсэлт, яамдаас эрх шилжиж ирүүлсэнээр зохион байгуулагдаж байгаа болно. Тухайлбал:

	Тендер шалгаруулалтын нэр	Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагааны явц
1	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын засварын ажил	100,000,000	100% ажил дууссан
2	Аймгийн Хулд сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	75,000,000	100% ажил дууссан
3	Аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн 1-р дотуур байрны дээврийн засвар	65,000,000	100% ажил дууссан
4	Ойн зурвас байгуулах ажил /Ногоон хэрэм/	20,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах тухай дүгнэлт зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. 100% ажил дууссан
5	Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хоол, хүнсний материал	26,500,000	100% бараа нийлүүлэгдсэн
6	Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шатахуун тслох материал	12,200,000	100% бараа нийлүүлэгдсэн
7	Аймгийн ЗДТГ-ын шатахуун, тослох материал	23,531,920	100% бараа нийлүүлэгдсэн

8	Аймгийн нэгдсэн эмнэлгийн хоол, хүнсний материал	110,162,000	100% бараа нийлүүлэгдсэн
9	Онцгой байдлын газар шатахуун, тослох материал	16,022,900	100% бараа нийлүүлэгдсэн
10	Аймгийн нэгдсэн эмнэлэгт шатахуун, тослох материал	33,525,300	100% бараа нийлүүлэгдсэн
11	Ойн зурвас байгуулах ажил	20,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах тухай дүгнэлт зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. 100% ажил дууссан
12	Адаацаг сумын сургуулийн нэгдсэн гадна дулааны шугамын засварын ажил	164,159,867	Гэрээ байгуулах эрх олгосон
13	Дундговь аймгийн музейн барилга, цэвэр, бохирын шугам, халаалтын засвар, дохиолол хамгаалалтын систем засвар	55,000,000	100% ажил дууссан
14	Ойн зурвас байгуулах ажил /Ногоон хэрэм/	20,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
15	Аймгийн төв номын сангийн засварын ажил	6,700,000	100% ажил дууссан
16	Цагаандэлгэр сумын Цэцэрлэгийн барилгын дээвэр засвар	79,500,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
17	Төв халхын дуулалт жүжгийн театрын дээврийн засварын ажил	40,000,000	100% ажил дууссан
18	Ойн зурвас байгуулах ажил	20,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
19	Модель хаус	70,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
20	Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын цэвэр усны холболтын ажил	92,467,935	100% ажил дууссан
21	Цэнгэлдэх хүрээлэнгийн дотор гадна тохижилтын ажил	45,082,893	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
22	Нэгдсэн эмнэлгийн гемодиализийн ус эрдэсгүйжүүлэх төхөөрөмж	30,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн.
23	Цахим аймаг хөтөлбөр	26,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн.

24	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	13,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн.
25	Хулд сумын цэцэрлэгийг хашаажуулах	15,000,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн.
26	Өндөршил сумын Музейн байрны засварын ажил	72,900,439	100% ажил дууссан
27	Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар	58,000,000	100% ажил дууссан
28	Аймгийн ЗДТГ-ын өрөө танхимын их засвар	38,110,912	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
29	Орон нутгийн өмчийн байрны засварын ажил	12,457,600	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
30	Аймгийн ЗДТГ-ын тохижилт	33,243,400	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
31	Аймгийн ЗДТГ-ын тоног төхөөрөмж	15,911,000	Харьцуулалт амжилтгүй болсоноор гэрээ шууд байгуулах зөвлөмж хүргүүлсэн. 100% ажил дууссан
32	Хүүхдийн парк- МТ колонк хүртэлх явган хүний зам	144,410,468	Гэрээ байгуулах эрх олгосон
33	Аймгийн төвийн авто замын засвар болон хэвтээ тэмдэг тэмдэглээний ажил	54,721,000	100% ажил дууссан

1.3 2017 онд хийхээр төлөвлөгдсөн худалдан авалтуудаас, техникийн тодорхойлолт ирүүлэгүйн болон бусад шалтгааны улмаас зохион байгуулагдаагүй хүлээгдэж байгаа Цэнгэлдэх хүрээлэнгийн гадна цахилгааны ажлын 50 сая төгрөгийн 1 худалдан авалтыг он дамжуулан 2018 оны II улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.

1.4 2017 онд зохион байгуулагдсан хийгдсэн бүх тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд , тендер нээснээс хойш 14 хоногт багтаан үнэлгээ хийх зорилт тавин үйл ажиллагааг журмын дагуу хэвийн явуулсан.

Одоогийн байдлаар тендерийн хүчинтэй хугацаанд хийгдээгүй худалдан авалт байхгүй байна.

1.5 2017 онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих “Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хяналтын төсөв үнийг зохиогдохдоо зах зээлийн хэт өнөдөр тооцсон буюу төсөв зохиох

норм, дүрмийг баримтлаагүй болох нь тогтоогдсон буюу өөрөөр хэлбэл 91 сая төгрөгийн төсөвт ажлыг оролцогч 60 сая төгрөгөөр гүйцэтгэх бүрэн боломжтой гэх тул захиалагчаас тус ажлыг аймгийн ИТХ-аар тодотгон хэлэцүүлэхээр болж тус зөрчлийг арилгахаар болсон.

1.6 2017 онд худалдан авах ажиллагаатай 7 тендер шалгаруулалтанд 8 гомдол гарсан бөгөөд үүний 5 нь Сангийн яаманд, 2 нь ШӨХТГ-т, 1 нь Шүүхэд нэхэмжлэл гаргаад байна.

#### Гомдол шийдвэрлэлтийн байдал

Тендер шалгаруулалтын нэр	Гомдол хүлээн авсан газар	Гомдол гаргагч ААН-ын нэр	Гомдол шийдвэрлэлтийн байдал
1 Аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн 1-р дотуур байрны дээврийн засвар	Сангийн яам	Дөл БГМ ХХК	Хүчингүй болгосон
2 Дундговь аймгийн музейн барилга, цэвэр, бохирын шугам, халаалтын засвар, дохиолол хамгаалалтын систем засвар	Сангийн яам	Баянгийн говь ХХК	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй
3 Адаацаг сумын сургуулийн нэгдсэн гадна дулааны шугамын засварын ажил	ШӨХТГ Сангийн яам	Ган-Илч ХХК	Өрсөлдөөнийг хязгаарласан Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй
4 Мандалговь хотын хуучин орон сууц /9, 13-р байр/ -ны гадна фасадны ажил	Сангийн яам	Дөл БГМ ХХК Баянгийн говь ХХК	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй
5 Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажил	Сангийн яам	Хөгжил хүмүүс ХХК	Дахин үнэлгээ хийх
6 Зөөврийн угсардаг тайз, гэрэлтүүлэг	Шүүх	Электронтехник ХХК	Шүүхэд хянан хэлэлцэж байгаа
7 Цахим аймаг хөтөлбөр	ШӨХТГ	Тэнүүн өргөө ХХК	Өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзсэн

1.7

#### Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар:

2.1. 2017 онд тендер шалгаруулалтыг аймгийн хэмжээнд бүрэн цахим хэлбэрт оруулах зорилт тавин ажилласан боловч Засгийн газрын худалдан авах ажиллагааны систем [tenders.gov.mn](http://tenders.gov.mn) /2016 оны жилийн эцсийн үеийн/ доголдолдож ажиллах боломжгүй болсон бөгөөд шинэ систем ашиглалтанд орох хүртэл тендер шалгаруулалтыг уламжлалт аргаар буюу цаасан хэлбэрээр 14 тендерийг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шилэн тендер бодлого хэрэгжүүлж төлөвлөгдсөн тендер шалгаруулалтын 30-аас доошгүй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2017 оны 4 дүгээр сараас Худалдан авах ажиллагааны нэгдсэн систем болох [tender.gov.mn](http://tender.gov.mn) ашиглалтанд орсоноор цахим хэлбэрээр зохион байгуулах нөхцөл боломж бүрдэж 2017 онд 35 тендер шалгаруулалт буюу нийт зохион байгуулах тендерийн 66%-ийг цахим хэлбэрээр зарлан зохион байгуулаад байна. 2017 онд [tender.gov.mn](http://tender.gov.mn) цахим системд

багагүй өөрчлөлт шинэчлэлтүүд хийгдэж одоогоор үйл ажиллагаа нь жигдэрсэн тул 2018 онд 15 сумын худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна.

2.2 2017 онд ерөнхий гэрээ байгуулах журам шинэчлэгдэж 2018 оноос хэрэгжиж эхлэнэ.

### **Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар**

3.1. Аймгийн 15 суманд орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөр 2017 онд нийт 2 тэрбум төгрөгийн 210 бараа, ажил худалдан авахаас 2018 оны 01 сарын 08-ны өдрийн байдлаар 190 худалдан авалтанд гэрээ байгуулагдаж 20 худалдан авалт санхүүжилтгүй улмаас зохион байгуулагдаагүй байна. Сумдын худалдан авалтаас 42 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

3.2. 2017 оны 02 сарын 08-10-ны өдрүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран Дэлхийн банкны санхүүжилтээр 15 сумын засаг даргын орлогч нарт мөн 20 гаруй ААН-үүдэд tender.gov.mn цахим системийн талаар болон 60 хүнд худалдан авах ажиллагааны



мэргэшүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулсан. Мэргэшүүлэх сургалтанд суралцагчдаас 23 хүн шалгалтандаа тэнцэж улмаар үнэлгээний хороонд томилогдон ажиллаж байна. “Тогтвортой амжиргаа-3” төсөлтэй хамтран 2017 оны 11 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд 15 сум тус бүрээс 3 хүн, аймгийн төвөөс 2 нийт 47 хүнийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамруулахаар төлөвлөж бэлтгэл ажлыг хангаад байна.





## Дөрөв. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаарх дүгнэлт, санал

4.1 2017 онд тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулах зорилт тавин ажилласан боловч [meps.gov.mn](http://meps.gov.mn) системийн доголдлоос шалтгаалан 1-3 дугаар сард зохион байгуулах тендерийг уламжлалт хэлбэрээр зохион байгуулсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [tender.gov.mn](http://tender.gov.mn)-ээр нийт зохион байгуулах тендерийн 40-өөс доошгүй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар ажилласан бөгөөд 35 бараа ажил буюу зохион байгуулсан тендер шалгаруулалтын 66%-ийг цахим хэлбэрээр зохион байгуулаад байна. Тус зорилтын хүрээнд орон нутгийн 17 ААН-д тоон гарын үсгийг олгоод байна. 2018 онд 15 сумын болон бусад байгууллагуудыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байна.



4.2 Гэрээний хэрэгжилт хяналт тавьж ажиллахаар Аймгийн Засаг даргын тамгын болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай санал солилцон бараа, ажлын хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд тус газраас томилж байхаар болж ажил хүлээн авах, 10, бараа хүлээн авах 15 нийт 25 улсын комист орж ажиллалаа..

2017 оны 04 сарын 14-15 ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дундговь аймгийн барилгачдын зөвлөгөөнд Орон нутгийн өмчийн газрын дарга, Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн нар оролцож барилгын компаниудад “Тендер шалгаруулалтанд хэрхэн амжилттай оролцох вэ” болон “цахим тендер хэрхэн оролцох”,



тоон гарын үсгийн ашиглалтын талаар мэдээлэл бэлтгэн илтгэл тавилаа. Мөн энэ үеэр тус зөвлөгөөнд оролцогчд ААН-үүдээс 1 компанийг азтанаар тодруулж тоон гарын үсгийг 100 хувийн хөнгөлөлттэй үнээр авах эрхийг бичгийг Б.Ням захиралтай “Мандал шилтгээн” ХХК-д гардуулж өглөө.

4.3 **Худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод явуулах зорилгоор:**

“2017 онд Худалдан авах ажлын аймгийн төлөвлөгөө” болон зарлаж байгаа ц

1. Улсын хэмжээнд өдөр тутмын “Зууны мэдээ” сонинд
2. Сангийн яамны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад

3. Аймгийн [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтад

4. Аймгийн Засаг даргын 7 хоног тутмын шуурхай мэдээллээр

5. Төлөвлөөг “Дундговийн амьдрал” сонинд тус тус иргэд, олон нийтэд зарлан мэдээлж байна.

Тайлан боловсруулсан: ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Адьяасүрэн

Хянасан: ОНӨГазрын дарга

С.Ууганбаяр

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР